



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 5 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 200


Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системийн үйл ажиллагааны журам”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд үүрэг болгосугай.




Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Цахим хөгжил, харилцаа холбооны
сайдын үүрэг хариуцагч

Л.ЭНХ-АМГАЛАН



Засгийн газрын 2022 оны 200 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

**МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦАГЧААС НЭЭЛТТЭЙ ӨГӨГДӨЛ БИЙ БОЛГОХ,
НИЙТЛЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА,
АШИГЛАХ НӨХЦӨЛ, ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь мэдээлэл хариуцагч Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12.1-д заасны дагуу нээлттэй, хаалттай болон хязгаарлалттай мэдээллээс нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журмыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх, ашиглахад Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актыг дагаж мөрдөнө.

Хоёр.Нээлттэй өгөгдөл бий болгох

2.1.Мэдээлэл хариуцагч нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12.1-д заасан нээлттэй өгөгдлийг бий болгоход дараахь шаардлага тавигдана:

- 2.1.1.хууль ёсны эх сурвалжаас цуглуулсан байх;
- 2.1.2.магадлахад үнэн зөв, бодитой байх;
- 2.1.3.агуулгын хувьд хэсэгчлээгүй, бүрэн гүйцэд байх;
- 2.1.4.хувийн ашиг сонирхол, итгэл үнэмшлийн нөлөөлөл ороогүй байх;
- 2.1.5.мэдээллийн сангийн нэгдсэн ангилал, код ашигласан байх;
- 2.1.6.нээлттэй өгөгдлийг бусад нээлттэй өгөгдөлтэй холбож ашиглах боломжтой байх;
- 2.1.7.нээлттэй өгөгдлийн мөр бүрийг ялган таних, бусад нээлттэй өгөгдөлтэй холбох түлхүүр талбартай байх;
- 2.1.8.түлхүүр талбарыг аль болох өөрчлөхгүй, урт хугацаанд тогтвортой хэрэглэдэг байх;
- 2.1.9.хууль тогтоомжоор зөвшөөрсөн, шинжлэх ухааны үндэслэл бүхий, энгийн, ойлгомжтой, нийтлэг хэрэглэгддэг нэр томъёо, агуулга, тоо, үсэг, тусгай тэмдэглэгээ ашигласан байх;